PUBLIC

Төв Азийн Эмэгтэйчүүдийн Бизнес Эрхлэгчдийг дэмжих Хөтөлбөр II: Голомт Банк ХК

Байршил: Монгол Улс

Төслийн дугаар: 57897

Бизнесийн салбар: Банк, Санхүүгийн байгууллага

Төрөл: Хувийн хэвшил

Батлах огноо: 2026 оны 12 сарын 2

Төлөв: Судалгааны шатанд

Төслийн танилцуулга: Төв Азийн Эмэгтэйчүүдийн Бизнес Эрхлэлтийг Дэмжих II (CA WiB II) хөтөлбөрийн хүрээнд Голомт Банк ХК-д 12 сая ам.доллар хүртэлх барьцаагүй санхүүжилтийг олгоно. Тус санхүүжилт нь хоёр тэнцүү транчаар олгогдоно.

Төслийн зорилго: Монголын эмэгтэйчүүдийн удирддаг бичил, жижиг, дунд үйлдвэрүүдийг тэдний онцлог хэрэгцээнд зориулсан санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээний багцаар дэмжих, үүнд асаргаа үйлчилгээний салбарын санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх туршилтын бүрэлдэхүүн багтсан.

Шилжилтийн нөлөөллийн үнэлгээ: ETI оноо 78. Төсөл нь эмэгтэйчүүдийн бизнесийн санхүүжилтийн хүртээмж, хөдөлмөр эрхлэлт болон бизнес эрхлэлтийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүртээмжтэй ба өрсөлдөх чадвартай шилжилтийн зорилтуудыг дэмжинэ.

Харилцагчийн мэдээлэл: Голомт Банк нь Монголын хоёр дахь том арилжааны банк бөгөөд 2025 оны байдлаар 19.2 их наяд төгрөгийн хөрөнгө, 1.7 их наяд төгрөгийн өөрийн хөрөнгө, банкны салбарын нийт хөрөнгийн 22.3%-ийг эзэлж байна. Moody’s: B1/тогтвортой, Fitch: B+/тогтвортой, S&P: B+/эерэг үнэлгээтэй.

EBRD санхүүжилт

12,000,000 ам.доллар.

Нийт төслийн өртөг

12,000,000 ам.доллар.

Нэмэлт:

Шинэлэг санхүүгийн бүтэц - Анхдагч алдагдлын эрсдэлийн хамгаалалт болон үр дүнд суурилсан нөхөн олговорийн шинэлэг бүтэцтэй. Түүнчлэн Голомт Банк нь санхүүгийн эрсдэлийн удирдлага болон байгаль орчин, нийгмийн практик дахь EBRD-ийн туршлагаас хүртэнэ.

Байгаль орчин, нийгмийн үнэлгээ

PUBLIC

ESP 2024-ийн дагуу FI ангилалд хамаарна. Голомт банк нь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны (ЕСБХБ) харилцагч бөгөөд одоогийн санхүүжилтүүдийн хүрээнд Байгаль орчин, нийгмийн шаардлагуудын (Environmental and Social Requirements, “ESRs”) 2, 4 болон 9 дүгээр шаардлагыг хангаж байна.

Шинээр санхүүжүүлэх боломжтой дэд төслүүд нь эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих санхүүжилтэд чиглэх бөгөөд байгаль орчин, нийгмийн (“E&S”) эрсдэл харьцангуй бага байх төлөвтэй байна. Байгаль орчин, нийгмийн үндсэн эрсдэлүүдэд Голомт банкны Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоо (“ESMS”)-г хэрэгжүүлэх чадавх; санхүүжүүлсэн дэд төслүүдээс үүдэж болзошгүй нөлөөлөл болон холбогдох нийлүүлэлтийн сүлжээний эрсдэл; өндөр эрсдэлтэй салбар, газарзүйн бүсэд өртөх эрсдэл; хөдөлмөрийн нөхцөл болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлууд багтана. Байгаль орчин, нийгмийн магадлан шинжилгээгээр Голомт банкны ESMS нь санхүүжүүлэх боломжтой дэд төслүүдийн эрсдэлийн түвшинтэй нийцэж байна.

Голомт банк нь Байгаль орчин, нийгмийн шаардлагуудын 2, 4 болон 9 дүгээр шаардлагад нийцүүлэн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг үр дүнтэй үнэлэх, удирдах, хянах зорилгоор ESMS-ээ хэвээр хадгалж, зохих ёсоор хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнд ЕСБХБ-ны санхүүжилтээс хасах үйл ажиллагааны жагсаалт (E&S Exclusion List) болон санхүүгийн байгууллагуудад зориулсан ЕСБХБ-ны холбогдох удирдамжийг мөрдөх шаардлага багтана. Голомт банкны санхүүжилт авсан зээлдэгчид нь байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдал болон хөдөлмөрийн харилцаатай холбоотой үндэсний хууль тогтоомжийг дагаж мөрдөх ёстой.

Голомт банк нь ESMS-ийн хэрэгжилт, ЕСБХБ-ны шаардлагуудын биелэлт, дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний үр дүн болон байгаль орчин, нийгэмтэй холбоотой аливаа ноцтой үйл явдлын талаар ЕСБХБ-нд жил бүр тайлан ирүүлнэ. Мөн ESP 2024-ийн дагуу ESMS-ийн талаарх мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх үүрэгтэй.

Ногоон үнэлгээ

Төслийг шууд бус санхүүжилттэй хөрөнгө оруулалтад зориулсан ЕСБХБ-ны Парисын хэлэлцээртэй нийцүүлэх аргачлалыг хэрэглэсний үндсэн дээр Парисын хэлэлцээртэй нийцсэн гэж тодорхойлсон. Нийцлийг тодорхойлохдоо дараах хоёр тулгуур шалгуурыг ашигласан. Үүнд:

1. Харилцагч тал Парисын хэлэлцээрийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үүрэг амлалт хүлээсэн эсэх.
2. Дамжуулан санхүүжүүлэх дэд гүйлгээнүүдийг холбогдох шалгуурын дагуу шүүх буюу үнэлэх тогтолцоо.

Техникийн хамтын ажиллагаа

1. Техникийн хамтын ажиллагаа (“TC”)

(i) Хамтрагч санхүүгийн байгууллагуудад үзүүлэх техникийн туслалцаа:

Хамтрагч санхүүгийн байгууллагуудад үзүүлэх техникийн туслалцаанд Хөтөлбөрийн зөвлөхүүдийн (“Consultants” буюу “PC”) дэмжлэг туслалцаа багтах бөгөөд энэ нь эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих санхүүжилтийн (Women in Business, “WiB”) зээлийн үйл ажиллагааг амжилттай өргөжүүлэх зорилгоор байгууллагын чадавхыг бэхжүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжихэд чиглэнэ.

Техникийн туслалцааны хөтөлбөр нь хамтрагч санхүүгийн байгууллагуудад эмэгтэйчүүдийн удирдлага дор үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд бизнесүүдийн (“WiB SMEs”) онцлог хэрэгцээнд нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүн, зээл олголтын арга барилыг хөгжүүлэхэд чиглэнэ.

Зөвлөхүүд нь мөн халамжийн эдийн засгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг бизнесүүдэд зээл олголтыг нэмэгдүүлэх сонирхол, боломжтой санхүүгийн байгууллагуудыг тодорхойлж, тэдэнтэй идэвхтэй хамтран ажиллах замаар уг сегментэд оролцох боломжтой санхүүгийн байгууллагуудын төслийн багцыг бүрдүүлнэ.

- Санхүүжилтийн эх үүсвэр: Women Entrepreneurs Financing Initiative, “We-Fi”) болон Европын Холбооны EFSD+.
- Хэмжээ: CA WiB II хөтөлбөрийн хэмжээнд 6 сая ам.доллар.
- We.Care бүрэлдэхүүний хэмжээ: 2.17 сая ам.доллар.
- Харилцагчийн хувь нэмэр: ЕСБХБ-ны Харилцагчийн хувь нэмрийн бодлого (BDS20-119/Rev 1) болон холбогдох удирдамжийн дагуу Голомт банкнаас техникийн туслалцаанд зориулж 28,000 ам.доллар хүртэлх хэмжээний нэмэлт хувь нэмэр оруулахыг хүснэ. Энэхүү хувь нэмрийг сургалт, WiB-тэй холбоотой бүтээгдэхүүний сурталчилгаанд ашиглах семинар, арга хэмжээ, маркетингийн үйл ажиллагаа болон материалын зардалд зориулан гаргаж болно.

(ii) ЖДҮ-ийн техникийн туслалцаа, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа

Жижиг, дунд бизнесийн чадавх бэхжүүлэх техникийн туслалцааг ЕСБХБ-ны Жижиг бизнесүүдэд зөвлөгөө өгөх хөтөлбөртэй хамтран, уялдаа холбоотой хэрэгжүүлнэ.

- Санхүүжилтийн эх үүсвэр: We-Fi, ЕХ-ны IFCA 3 болон SBIF SECO.
- Хэмжээ, валют: Хөтөлбөрийн хэмжээнд 2.8 сая евро.

2. Хамтарсан хөрөнгө оруулалтын буцалтгүй тусламж / хөнгөлөлттэй санхүүжилт

Үр дүнд суурилсан нөхөн олговор (“RBC”)

WiB зээлийн дүнгийн 3% хүртэлх хэмжээний RBC бүрэлдэхүүн нь WiB зээлийн үйл ажиллагааг тогтвортой өргөжүүлэхэд шаардлагатай анхны хөрөнгө оруулалтын зардлын тодорхой хэсгийг Голомт банкинд нөхөн олгох зорилготой. Үүнд:

1. CA WiB II хөтөлбөрийн хүрээнд жендэрт чиглэсэн ЖДҮ-ийн шинэ бүтээгдэхүүн боловсруулах, нэвтрүүлэх;
2. Дотоод бодлого, журамд өөрчлөлт оруулах;
3. Удирдлагын мэдээллийн систем (MIS)-ийг шинэчлэх болон бусад өндөр өртөгтэй дэд бүтцийн өөрчлөлт хийх;
4. Хөтөлбөр болон холбогдох бүтээгдэхүүнийг зах зээлд сурталчлах зэрэг зардал багтана.

- Санхүүжилтийн эх үүсвэр: We-Fi.

- Хэмжээ: 360,000 ам.доллар.

We.Care бүрэлдэхүүний үр дүнд суурилсан нөхөн олговор

We.Care бүрэлдэхүүний хүрээнд санал болгож буй WiB зээлийн дүнгийн 3% хүртэлх хэмжээний үр дүнд суурилсан нөхөн олговор олгохоор төлөвлөсөн. Энэхүү нөхөн олговор нь WiB зээлийн үйл ажиллагааг тогтвортой өргөжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийг бий болгохтой холбоотой Голомт банкны анхны хөрөнгө оруулалтын зардлын тодорхой хэсгийг нөхөх зорилготой.

- Санхүүжилтийн эх үүсвэр: We-Fi We.Care.

Холбоо барих: Б.Энхзаяа, Олон улсын банкны газрын захирал, enkhzaya_b@golomtbank.com, +976 7575-1111

Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга хандлагын талаарх нэмэлт мэдээллийг эндээс авна уу.

Бизнес боломжууд

Бизнес боломжууд болон худалдан авалтын талаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хамтран ажиллах боломжууд (худалдан авалттай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл ЕСБХБ-ны Худалдан авалт хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг ЕСБХБ-ны Лавлагааны маягт ашиглан авах боломжтой.

Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

БОНБ болон холбогдох Байгаль орчин, нийгмийн шаардлагууд (БОНШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг хөхиүлэн дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон БОНШ-д үйлчлүүлэгчийн зүгээс олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн талаарх үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөх , мөн оролцогч талуудын санал гомдол, ялангуяа үйлчлүүлэгч ба төслийн байгаль орчин болон нийгэм (БОН)-ийн гүйцэтгэлийн

талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан байдаг. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн, тухайн төслийн эрсдэл, үр нөлөөллийн тухай мэдээллийг шаардлагын дагуу ил болгох, эсвэл оролцогч талуудтай утга учиртай зөвлөлдөх, тэдний санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу өгөх шаардлагыг үйлчлүүлэгчиддээ тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг практикийн талаарх нэмэлт мэдээллийг БОНБ-д оруулсан болно.

Бүрэн төгс байдал ба комплаенс

ЕСБХБ-ны Комплаенс хариуцсан Захирлын Ажлын алба (КЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг практикт нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаан дахь бүрэн төгс байдлыг хамгийн дээд стандартаар хангахад анхаарч ажилладаг. Төслүүдийн зүгээс Банкинд бүрэн төгс байдал, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд тус Банк бүх үйлчлүүлэгчийнхээ бүрэн төгс байдалд нарийвчилсан үнэлгээ хийдэг. ЕСБХБ нь аливаа асуудлыг төслийн үнэлгээний болон төсөл батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны транзакцийн бүрэн төгс байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. КЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэж, төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах бүрэн төгс байдлын эрсдлийг хянахад тус дөхөм үзүүлдэг.

Цаашилбал, КЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга, хээл хахууль болон буруу үйлдлийн талаарх гомдлын мөрөөр судлан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд, эсвэл Банкны бус хэн ч бай залилан мэхлэлт болон авилгал үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй тохиолдолд Комплаенс хариуцсан захиралд compliance@ebrd.com цахим шуудангийн хаяг руу бичгээр илтгэх ёстой. КЗАА нь мэдээлэгдсэн бүхий л асуудлын мөрөөр ажиллана. Мөн мэдээлэгдсэн бүх асуудлыг хянан шийдвэрлэх ажил гүйцэтгэнэ. Мэдээллийг Банкны албан ёсны хэл болон үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын хэлний алинаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь чин сэтгэлийн байх ёстой.

Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

2025 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн МХБ нь ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил тод болгох, өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэн сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг тодорхойлсон байдаг. ЕСБХБ-ны вэб сайтаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдье гэвэл Мэдээллийн хүртээмжийн бодлого хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтээ ЕСБХБ-ны Лавлагааны маягт ашиглан илгээх боломжтой.

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой санал гомдлоо үйлчлүүлэгч болон Банкинд тавьж шийдвэрлүүлэх (жишээлбэл: үйлчлүүлэгчийн төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харилцах замаар) оролдлого, хүчин чармайлт нь амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд санал гомдлоо ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)-аар дамжуулан шийдвэрлүүлэхийг зорьж болно.

ТХХБМ нь төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан (эсвэл учруулж болзошгүй) гэж үзэж буй асуудлуудыг хараат бусаар хянан шалгадаг. Энэхүү механизмын зорилго нь байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох асуудлуудыг шийдвэрлэх талаар төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлэлцээг дэмжих; Банк өөрийн Байгаль орчин, нийгмийн бодлого, эсвэл Мэдээллийн хүртээмжийн бодлого–ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс эдгээр бодлогод үл нийцсэн зөрчлийг арилгах, түүний зэрэгцээ цаашид тийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

ТХХБМ болон түүний эрх үүргийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл Төслийн хариуцлагын хараат бус механизмын вэб сайт, хянан шалгуулах хүсэлт тавих бол Хүсэлт хаягаар тус тус хандана уу. Эсвэл ТХХБМ-ын талаар, мөн санал хүсэлт хэрхэн тавих тухай чиглэл заавар, нэмэлт мэдээлэл авах бол ipam@ebrd.com цахим шуудангаар хандаж болно.

Энэ нь Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас дээр заасан Төслийн дугаар болон огноогоор англи хэл дээр хэвлэн гаргасан Төслийн хураангуй баримт бичгийн эх хувийн орчуулга болно. Хэрвээ англи хэл дээрх эхийн аливаа бичвэр нь тус орчуулгатай нийцэхгүй байвал Төслийн хураангуй баримт бичгийн англи хэл дээрх эх хувийг баримтлана.